

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 12дугаар сарын 10

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж, чиглэлийг удирдлага болгон Улсын бүртгэлийн багц хуулийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилтыг хангахад онцгойлон анхаарал хандуулахыг зэрэгцээ улс орон даяар үүсээд буй цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг чанд биелүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2020 оны үйл ажиллагааны энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах, Ерөнхий газар болон аймаг, орон нутгаас зохион байгуулалсан нэгдсэн арга хэмжээнд хэрхэн хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил үйлчилгээг улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээтэй нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- Бодлого, шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт;
- Улсын бүртгэлийн хууль тогтоомж, стандартын хэрэгжилт
- Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлт;
- Улсын бүртгэлийн (иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн)

үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;

- Бүртгэлийн хяналт;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж,

программ хангамжийн сайжруулалт;

- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;
- Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтаж

хийсэн ажлын талаар

НЭГ. БОДЛОГО, ШИЙДВЭР, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

1.1.1. Үндэсний төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт:

Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр батлан гаргасан хөтөлбөрүүдээс тус хэлтэс дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллав.

- 1.“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн хэрэгжилт;
2. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
3. Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- 4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт
- 5.Терроризмтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- 6.Авлигатай тэмцэх соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт

Дээрх төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчийг жил бүр өөрчлөн түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Дэд хөтөлбөрийн биелэлтийг хөтөлбөр тус бүрээр гарган заасан хугацаанд тогтмол тайлагнаж, жилийн эцэст архивын нэгж болгон үдэж архивт хүлээн авч хэвшсэн.

ХОЁР. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлого хэмээх Тавдугаар зүйлийн 5.2.8-д улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, 5.2.10-д “**Нэг иргэн, нэг бүртгэл**” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй болгохоор тусгасан стратегийг

хэрэгжүүлж Монгол Улсын Их Хурлаас 2018 онд Улсын бүртгэлийн багц хуулиудыг шинэчлэн баталж хэрэгжүүлснээр бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээ цахимаар явж хэрэгжиж байгаа хэдий ч иргэдийн энэ талаарх мэдлэг мэдээлэл дутмаг, цахимаар авсан лавлагаа үйлчилгээгээр зарим нэг банк байгууллага үйлчилгээ үзүүлэхгүй байх зэрэг бэрхшээл байсаар байна.

Шинээр даган мөрдөж буй Улсын бүртгэлийн багц хуулиуд нь Улсын бүртгэлийн олон улсын чиг хандлагад нийцсэн бүртгэлийн үйлчилгээг бий болгох, төгөлдөршүүлэх үйл явцыг эрчимжүүлснээр улсын бүртгэлийн 26 төрлийн лавлагаа үйлчилгээг цахимаар авахад орон нутаг дахь хэлтэс бүртгэлийг үнэн зөв, түргэн шуурхай цахимжуулж ажилласнаар өөр өөрийн зохих хувь нэмрийг оруулан ажиллаж байна.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн үйлчилгээний стандартыг чанд мөрдөн ажиллаж 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар **нийт 29099** бүртгэлийг бүртгэн, мөн тооны иргэд, аж ахуй нэгж, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

Байгууллагаас ажилтнууддаа оюуны хөрөнгө оруулалт хийхэд анхаарч ажиллаж байгаа ба энэ онд “Төрийн албан хаагч ба иргэдийн харилцаа”, “Хандлага таны амжилтын луужин” сэдвүүдээр шилдэг лекторуудыг урьж ажилласнаар үйлчилгээний стандартыг биелүүлж иргэд үйлчүүлэгчтэй мэндэлж, хүндэлж, сонсон аливаа харилцааны эхлэл нь түүнээс эхтэй гэдгийг ажилтан нэг бүр ухамсарлан хэрэгжүүлсэн гэж дүгнэхэд таатай байна. Ийнхүү ажиллах эрч хүч, урам зоригоор дүүрэн хамт олон маань байгууллагын төсөвт ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад хүрэлцэхүйц зардал батлагдаж ирдэггүй ч өөрсдөө санаачилан хар хөх өнгийн хослол /пиджак юбка, цагаан цэнхэр өнгийн цамц/оор жигдэрч ажилтнууд өөрсдийн ажлын хөлсөөрөө захиалан хийлгэж байгууллагынхаа нүүр царайг өдрөөс өдөрт өөд татан төрийн байгууллагын нэр хүндийг өндөрт өргөж ажиллахад хоёргүй сэтгэлээр хамтран ажиллаж байна.

ГУРАВ. УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

3.1.Ерөнхий газраас болон бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

Дэлхий даяар үүсээд буй цар тахалтай холбоотойгоор 2020 оны 1, 2 дугаар улиралд УБЕГ-ын даргын 2020 оны 03 сарын 13-ны өдрийн А/259 “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” тушаал, 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/419 “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тушаал, 2020 оны 04 сарын 30-ны өдрийн А/554 тоот “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тушаалуудыг хэрэгжүүлэн ажиллаж тухай бүр илтгэх хуудсыг a.khulan@burtgel.gov.mn, d.munkhtuya@burtgel.gov.mn хаягаар, 4 дүгээр улиралд МУ-ын Онцгой комиссын шийдвэрүүд, МУ-ын Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх

тухай”, “Өндөржүүлсэн бэлэн байдлийн зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолуудыг хэрэгжүүлж хэлтсийн даргын тушаалаар хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж өдөр бүр маягтын дагуу мэдээг тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Нэг. Иргэний бүртгэлийн чиглэлээр

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 5/10244 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуулийг улсын бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу зохион байгуулах буюу сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв үйлдэх, иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор нэг хаяг дээр 10-аас дээш иргэн бүртгэлтэй хаягийг тодруулах ажлыг зохион байгуулж аймгийн төвийн 11 багийн нэг хаяг дээр 10-аас дээшгүй иргэд бүртгэлтэй гэх иргэдийг хаяг тус бүрээр очиж тухайн хаягт одоо байнга оршин сууж байгаа иргэдийг тодруулж songuuli2020@burtgel.gov.mn хаягаар Иргэний улсын бүртгэлийн газарт тайлагнаж ажилласан.

УБЕГ-ын 1 сарын 28-ны өдрийн 5/850 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу ажлыг зохион байгуулж хяналт тавин илтгэх хуудсыг ts.javkhlant@burtgel.gov.mn хаягаар 2 дугаар сарын 03-ны өдрийн 17.08 минутад хүргүүлэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/372 тоот тушаалын хэрэгжилтийн талаар

-Тус тушаалаар батлагдсан “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”-ын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт заасны дагуу “Сонгуулийн хэсэг байгуулсан тухай” 20 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүлээн авч, нутаг дэвсгэр төвийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим сан дахь сонгогчийн бүртгэлд тусгаж, скайнердаж, эх хувийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд заасан дагуу иргэдийг хаягийн дагуу хэсэг оноолтыг 100 хувь хийж дуусган songuuli2020@burtgel.gov.mn хаягаар илтгэх хуудсыг хүргүүлсэн.

-Сонгогчийн шилжилт хөдөлгөөн, нас барсан, иргэний улсын бүртгэлд орсон өөрчлөлт, түр хасав сэргээсэн бүртгэл Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 1557ш лавлагаа хэвлэгдсэн ба журмаар батлагдсан маягтын дагуу холбогдох бүртгэлүүдийг хөтлөн явуулсан.

-Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж буй сонгуулийн хэсэг оноолтыг хийн Иргэний улсын бүртгэлийн газрын даргын **2020 оны 02 сарын 27-ны 5/1858 тоот** чиглэлийндагуу ажлуудыг хийж гүйцэтгэн ts.javkhlant@burtgel.gov.mn хаягаар.

-Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 5/3701 тоот санал ирүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн саналыг улсын бүртгэгчдээс авч илтгэх хуудсаар 5 сарын 14-ны 11.44 минутад t.enkhbaatar@burtgel.gov.mn хаягаархүргүүлэв.

-Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 20.00 цагт утсаар өгөгдсөн чиглэлийн дагуу тус хэлтсээс хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудсыг songuuli2020@burtgel.gov.mn хаягаар.

- УБЕГ-ын ИУБГ-аас ирүүлсэн 2020 оны 04 дүгээр сарын 21-ний 5/3846 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу ажлыг хийж гүйцэтгэн илтгэх хуудсыг 5 дугаар сарын 05-ны өдрийн 16 цаг 19 минутад songuuli2020@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 5/4911 тоот “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай” чиглэлийн биелэлт

Чиглэлд дурдсанаар Сонгогч шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөхөд шаардлагатай нотлох баримтуудыг нэг бүрчлэн хянаж ажилласан. Жишээлбэл: Сонгуулийн байгууллагын ажилтныг нотлох албан бичгийг ажилтан нэг бүрээр эх хувиар нь, цагдаагийн байгууллагын ажилтныг нотлох албан бичгийг хүн тус бүрээр, нэр дэвшигчийн шадар туслах, менежерийн жагсаалтыг Аймгийн сонгуулийн хорооноос гэх мэтчилэн нэг бүрчлэн авч хавсарган ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 8/5265 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн хэрэгжилт

Хяналт шалгалтын газрын дарга Б.Ганзоригийн ирүүлсэн чиглэлд дурдсанаар Сонгогч шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэхээр ирүүлсэн нотлох баримтыг хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяраар хянуулан, нотлох баримтанд хянасан тухай хяналтын тэмдэг даруулж, лавлагааг хэвлэсэн болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2/5447, 2020 оны 06 угаар сарын 04-ний өдрийн 8/5520 тоот чиглэлийн хэрэгжилт

Тус чиглэлд дурдсанаар сонгогч шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн ажлын цагаар тасалбар болгон бүртгэж, лавлагааг хэвлэн, сонгогчийн нэрийн жагсаалтанд холбогдох өөрчлөлтүүдийг бүрэн тусгаж ажилласан.

Баянхонгор аймагт санал өгөхөөр хасалтаа хийлгэсэн боловч сонгогч шилжин ирсэн бүртгэлээ хийлгээгүй 19 сонгогч байсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 5/3701 тоот “Санал авах тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Тус хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар нь Иргэний улсын бүртгэлийн шинэчилсэн системд туршилтаар нийт 625 бүртгэл хөтөлсөн. Бүртгэл хийх явцад гарч байгаа нийтлэг алдаанууд болон, нэмж тусгуулах 20 саналыг нэгтгэн Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

2020 оны 10 дугаар сарын сарын 27-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн газраас дотоод албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн талаар

Чиглэлийг нийт улсын бүртгэгчид танилцуулан, өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хууль, журмыг нэг мөр ойлгон чанд баримталж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11/9747 тоот “Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Тус албан бичигт “Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт”-ыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын газрын даргын хамтарсан А-1437/А-110 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан тухай тушаалыг хавсралтын хамт ирүүлснийг архивын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын архивын “баримт бичиг нягтлан шалгах комисс”-т устгах баримт бичгийн саналаа хүргүүлэхдээ шинэчилсэн жагсаалтыг сайтар судлан чанд мөрдөж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 161 тоот “Журмын төсөлд санал ирүүлэх тухай” дотоод албан бичгийн биелэлтийн талаар

“Монгол улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын төсөлд 6 саналыг өөрчлөх болон нэмж тусгуулахаар 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр b.narangerel@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн.

2.Бүртгэлийн хяналтын чиглэлээр:

-Хяналт шалгалтын газрын 2020 оны 01 сарын 09 -ний өдрийн 67 дугаартай албан бичгийн дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 10-ны өдрийн хооронд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд

хяналт тавьсан, мөн хяналт шалгалтын газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 31-ний өдрийн хооронд бүртгэгдсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд 4 удаа хяналт шалгалт хийж, холбогдох нотлох баримтуудыг скайнердаж оруулан хүргүүлсэн.

-Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 8/409 тоот үүрэг чиглэлийн хүргүүлэх тухай албан бичгийн биелэлтийг хангаж хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид тус бүр хуваарийн дагуу хийж гүйцэтгэн илтгэх хуудсыг b.galbadrakh@burtgel.gov.mn, zolbayar.t@burtgel.gov.mn хаягаар хугацаанд нь хүргүүлсэн.

-Хяналт шалгалтын газрын 4 дүгээр сарын 08-ны өдрийн 8/3377 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу ажлыг хийж гүйцэтгэн 4 сарын 13-ны өдөр Хяналт шалгалтын газар цахим шуудангаар хүргүүлсэн.

-2020 оны 05 сарын 18-ны өдрийн 2/4861 тоот албан бичгийн дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 31-ний өдрийн хооронд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт тавьж ажиллан илтгэх хуудсыг songuuli2020@burtgel.gov.mn хаягаар 25-ны өдрийн 21.03 минутад хүргүүлсэн.

-Хяналт шалгалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 7-ны өдрийн 8/4402 чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг хүлээн авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант 2020 он онцлох жил байлаа. Улсын их хурлын ээлжит сонгууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль болсонтой холбоотойгоор иргэний шилжилт хөдөлгөөний **1074** бүртгэл, орон нутгийн ээлжит сонгуультай холбоотой **1098** бүртгэл, нийт **2172** бүртгэлд хяналт тавин холбогдох нотлох баримтуудыг скайн хийж, PDF файл болгон хадгалсан болно.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 2/4861 тоот албан бичгийн дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд бүртгэгдсэн иргэний шилжилт хөдөлгөөний 1074 бүртгэл, бүртгэлийн нотлох баримтыг дахин шалгаж, 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр УБЕГ-т илтгэх хуудсаар хүргүүлэн ажилласан .

-Орон нутгийн сонгуультай холбоотой Хяналт шалгалтын газрын 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 8/6147 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний 1098 бүртгэлд хяналт тавьж, нотлох баримтуудыг нэг бүрчлэн шалгаж, скайндаж шилжин ирсэн иргэн бүрийн регистрийн дугаараар PDF файл үүсгэж, сум бүрээр ялгаж, мөн бүртгэлийн дэвтэрийг скайндаж файл үүсгэн албан бичигт заасны дагуу hyanal@burtgel.gov.mn цахим шуудангаар тайланг илгээж, харин скайдан PDF болгосон файлаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод сүлжээ /network -192.168.154.100/ -ний 07.hyanalt гэсэн дундын хавтас /folder/ -т байрлуулж ажилласан байна.

3.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын **2019 оны 7/9562 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд бүртгэлийн үйлчилгээний төрөл буруу сонгож бүртгэн цахимжуулсан гэх 12 хувийн хэргийг, мөн газрын даргын **2020 оны 7/1960 тоот албан бичгээр ирүүлсэн** чиглэлийн дагуу Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд анх удаа бүртгэхдээ цахим мэдээллийн санд газрын нэгж талбарын дугаар тусгаагүй алдаатай бүртгэсэн гэх 58 хувийн хэргийг нэг бүрчлэн цаасан суурьт эх нотлох баримттай тулган шалгаж, улмаар Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан цахим системд алдааг засаж, холбогдох тайланг заасан хугацаанд нь гарган Илтгэх хуудсаар suvderdene@burtgel.gov.mn, edkhourungu@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлсэн.

4.Бусад

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/127 тоот албан бичгээр ирүүлсэн “Коронавируст халдвараас (COVID-19) урьдчилан сэргийлэх зөвлөмжийн биелэлтийн талаар:

Тус газраас ирүүлсэн зөвлөмжид дурьдсан заалт тус бүрийг тус хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэд болон албан хаагч нар чанд мөрдөн ажиллаж байгаа талаарх тайланг сар бүрийн 25-ны дотор namjilmaa.l@inspection.gov.mn хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Баянхонгор аймгийн Төрийн архивын тасгийн 2020 оны 01 дүгээр сарын 20-ны 1/58 тоот “Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг ирүүлэх” албан бичгийн биелэлтийн талаар:

Энэ албан бичгийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/190 мэдээг гарган Төрийн архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэгт хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 11/3283 тоот “Санал авах тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын 2014 оны 05 сарын 26-ны өдрийн 714/А-91 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан ББХЖагсаалтад нэмүүлэхээр 30 төрлийн санал боловсруулан 04 дүгээр сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Нэгдсэн архивын газрын даргад файлаар болон цаасаар хүргүүлэн ажилласан.

-УБЕГ-ын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 3/2400 чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу ажлыг зохион байгуулж ya.maralmaa@burtgel.gov.mn хаягаар 3 сарын 20-ны 16.12 минутад тайланг хүргүүлсэн.

УБЕГ-ын 5 сарын 21-ний 3/5006 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу бэлтгэл ажлыг хангаж техник хэрэгслийг хуваарийн дагуу татан авч товлосон хугацаанд сургалтыг амжилттай зохион байгуулж явууллаа.

Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020.12.01-ний өдрийн 3/1848 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Дэлхийн 187 улс жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг “Өрх гэр ажлын байр, олон нийтийн газарт ЯГ ОДОО жендэрт суурилсан хүчирхийллийг цэглэе” уриан дор зохион байгуулсан ажлын тайланг ariunjargal@mojha.gov.mn хаягаар 12 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн.

5.Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас 6/10300 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл болон УБЕГ-ын даргын “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай ”2020 оны А/259 тоот тушаал, хэлтсийн даргын 2020 оны А/04 тоот тушаалыг үйл ажиллагаандаа уидрдлага болгон ажиллаж байна.

-УБЕГ-ын 2020 оны 6/6646 тоот чиглэлийн дагуу “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган “Илтгэх хуудас”-ыг ХЭБГ-т 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр ERS сүлжээгээр хүргүүлсэн.

- ХЭБГ-аас ирүүлсэн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 6/6943 тоот албан бичгийн дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй Шашны байгууллагын судалгааг гаргаж аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй эсэхийг тулган шалгаж холбогдох шашны байгууллагын тэргүүн болон холбогдох эздэд Хэлтсийн даргын 2020 оны 1-/996 дугаар бүхий албан тоотоор хүргүүлж хэрхэн ажилласан тухай “Илтгэх хуудас”-ыг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ХЭБ-ийн ERS программын мэдээ мэдээлэл хэсэгт байршуулан хүргүүлсэн.

Харин ХЭБГ-аас ERS программаар санал авах тухай дараах албан бичгүүдэд доорх байдлаар хариуг өгч ажиллалаа. Үүнд:

- 1.Эцсийн өмчлөгчийн бүртгэлийн маягтад 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр.
- 2.Бүртгэлийн ERS программд өөрчлөлт оруулах тухай 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр.
- 3.УБ-03, УБ-05, УБ-12 маягтуудад 2020 оны 05 дугаарын сарын 07-ны өдөр.
- 4.Бүртгэлийн цахим гэрчилгээний төсөлд 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр.

5.Орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудын судалгааг Аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран тулган шалгаж хүргүүлээ.

ДӨРӨВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;

Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Шинэчлэгдсэн Улсын бүртгэлийн багц хуулиудыг мөрдөж эхэлсэнтэй холбоотой бүртгэлийн журмууд шинэчлэгдэж мөрдөгдөөд даруй 2 жил гаруй хугацаа өнгөрч иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байна.

4.1. Иргэний улсын бүртгэл:

Тайлант хугацаанд Иргэний бүртгэлийн тасаг нь дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

1.Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахаар УБЕГ-аас батлагдсан төлөвлөгөөний дагуу тус Улсын бүртгэлийн хэлтсээс 18 заалт арга хэмжээ бүхий дэд төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай биелэгдсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгууль орон даяар явагдахтай холбогдуулан зохион байгуулагдсан ажлуудаас дурдвал:

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон зогсоож, хуулийн хугацаанд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хугацаанд нь бүртгэн, баталгаажуулан ажиллаж илтгэх хуудсыг songuuli2020@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэв.

-Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 20.4-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдийн Сонгогчдын нэрийн жагсаалтанд орсон эсэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудаснаас шалган өгч ажилласан. Мөн мэдээлэл зөрүүтэй гэсэн 4 иргэнтэй утсаар болон биечлэн холбогдож

мэдээллийг шалган, ямар нэгэн зөрүүгүй болох талаар илтгэх хуудсыг ts.javkhlant@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн.

- Аймгийн хэмжээнд нийт 105 сонгуулийн хэсэгт 114 итгэмжлэгдсэн ажилтан ажилласан ба нийт 57149 сонгогчдын хэсэг оноолтыг 100 хувь оноож, сонгогчдын нэрийг жагсаалтанд зөв тусгагдсаныг хянаж ажилласан.

- Сонгогч шилжин явсан, ирсэн, иргэний улсын бүртгэлд өөрчлөлт орсон, нас барсан нийт 1557 лавлагааг нотлох баримтыг үндэслэн хэвлэж, холбогдох хэсгийн итгэмжлэгдсэн ажилтнуудад хүлээлгэн өгч, сонгогчийн нэрийн жагсаалтанд холбогдох өөрчлөлтүүдийг тусган ажилласан. Мөн түр хасав тэмдэглэгээтэй 9 сонгогчийн хүсэлт, нотлох баримтыг үндэслэн лавлагааг хэвлэн түр хасав тэмдэглэгээг сэргээж, сонгогчийн нэрийн жагсаалтанд өөрчлөлт оруулсан болно.

- УБЕГазраас зохион байгуулсан Монгол Улсын Их Хурлын сонгуульд Иргэний бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллах Итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн болон тоног төхөөрөмжийн сургалтыг Улсын бүртгэлийн хэлтэс нь онлайнаар 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдөр, танхимаар 2020 оны 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулсан.

- Итгэмжлэгдсэн ажилтнууд нь нийт 1557 лавлагааг сонгогчийн нэрийн жагсаалтанд үнэн зөв, хариуцлагатай тусгаж, сонгогчийн нэрийн жагсаалтад өөрчлөлтийг оруулан хэвлэж, өөрчлөлт орсон сонгогч нэг бүрээр тулган шалгаж ажилласан.


- Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 4 принтер дээр сонгуулийн 105 хэсгийн сонгогчдийн нэрийн жагсаалтыг тус бүр 3 хувь хэвлэж, хэлтсийн даргын тамга, гарын үсгээр баталгаажуулан 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд, 1 хувийг Улсын бүртгэлийн хэлтэст авч, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгч цагдаагийн хамгаалалт дор холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

Итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг зохион байгуулахдаа аймгийн Онцгой байдлын газрын зөвшөөрөлтөйгөөр Онцгой байдлын газрын спорт зааланд ариутгал, халдваргүйтэл хийж, халууныг нь хэмжиж, ажилтнуудын хоорондын зайг баримтлан сургалтаа зохион байгуулж ажилласан.

- Сургалтын явцад Бөмбөгөр сумын нетбүк ажиллахгүй байсныг аймгийн Тагнуулын хэлтсийн ажилтны хяналтан дор засварласан, мөн ажиллагаагүй 2 уртасгагч залгуурыг шинэчлэн сольж олгов.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд нийт 117888 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэл хөтөлсөн нийт 11337 ширхэг ИУБ маягтыг “Архивт маягт хүлээлцэх бүртгэл” болон нэрийн жагсаалтын хамт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивт хүлээн авч хувийн хэргийн нэгдсэн санд нэг бүрчлэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажиллалаа. Үүнийг доорх графикаар харуулвал:



Жилийн эцсийн байдлаар өөр аймаг, хотруу бүр мөсөн шилжин явсан нийт 334 иргэний хувийн хэргийг жагсаалтын хамт хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлж ажилласан байна. Тухайлбал:

1. Улаанбаатар хотруу 169 иргэний хувийн хэрэг
2. Өмнөговь аймагруу 31 иргэний хувийн хэрэг
3. Дархан-Уул аймагруу 20 иргэний хувийн хэрэг
4. Сэлэнгэ аймагруу 10 иргэний хувийн хэрэг
5. Орхон аймагруу 10 иргэний хувийн хэрэг
6. Төв аймагруу 19 иргэний хувийн хэрэг
7. Архангай аймагруу 6 иргэний хувийн хэрэг
8. Дорноговь аймагруу 9 иргэний хувийн хэрэг
9. Өвөрхангай аймагруу 41 иргэний хувийн хэрэг
10. Говь-Алтай аймагруу 14 иргэний хувийн хэрэг
11. Булган аймагруу 2 иргэний хувийн хэрэг
12. Ховд аймагруу 2 иргэний хувийн хэрэг
13. Хөвсгөл аймагруу 1 иргэний хувийн хэрэг

Мөн иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 14.2- дахь заалт **“Аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь өөр засаг захиргааны нэгжээс шилжин ирсэн иргэний хувийн хэргийг ажлын 21 өдрийн дотор холбогдох аймаг, нийслэл дэх улсын бүртгэлийн газар, хэлтсээс татан авна”**. гэж заасны дагуу online программын “Шилжин ирсэн иргэний жагсаалт”-ын дагуу өөр аймаг, хотоос бүр мөсөн шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг аймаг тус бүрээс албан бичгээр шаардан нийт **552** иргэний хувийн хэрэг, маягтыг архивт хүлээн авч, бүртгэн хувийн хэргийн нэгдсэн санд байршуулж баяжилтыг тогтмол хийн ажиллаж байна.

Мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн хувийн хэрэг болон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Хэлтсийн дарга, Тасгийн дарга, Хяналтын улсын байцаагч, Улсын бүртгэгч нарт “Архиваас хувийн хэрэг захиалах хуудас”-аар нийт 221 иргэний хувийн хэрэг, “Архиваас бүртгэлийн дэвтэр захиалах хуудас”-аар 718 ширхэг бүртгэлийн дэвтрийг архивын сангаас гаргаж, буцаан хүлээн авч санд байршуулан ажилласан байна.

Архивын баримтын эмх цэгцийг хангаж ажиллахаар 2003 онд төрсөн 2019 онд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдаж иргэний цахим үнэмлэхээ шинээр авах ёстой боловч өнөөг хүртэл бүртгэлд хамрагдаагүй үлдсэн иргэдийн архивын санд хадгалагдаж буй 383 ширхэг хаатр-11 маягтыг улсын бүртгэлийн мэдээллийн санд нэг бүрчлэн шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- 114 иргэн нь биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдаагүй /сум тус бүрээр жагсаалт үйлдэн хэлтсийн дотоод хаалттай группэд байршуулж сумдын улсын бүртгэгч нарт мэдээллэж ажилласан/
- 218 иргэн өөр аймаг, хотруу бүр мөсөн шилжин явсан /харъяалах аймаг, хотруу хувийн хэрэг, маягтыг албан бичгээр хүргүүлсэн/
- 4 иргэн нас барсан /ИУБ-18 санд нэмж байршуулсан/
- 47 иргэний хаатр-11 маягт овог, нэр, регистрийн дугаар нь зөрүүтэй бичигдсэн / хувийн хэрэгт нэгтгэн санд байршуулан ажилласан/.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс нь 2020 оны 2 сард ээлжилт хуралдаанаа хийж 2019 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчилж 2020 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинээр батлан мөрдөж ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэгч нараас 2019 оны бүртгэлийн дэвтэр, бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичгийг архивт хүлээн авахдаа баримтын үдэлт, дугаарлалт, нүүр, ашиглалтын хуудас, дотоод товъёг, баталгааны хуудас, бүртгэгчийн гарын үсэг зэргийг нягтлан шалгаж нийт 436 ширхэг хадгаламжийн нэгжийг “2019 оны бүртгэл, нотлох

баримт хүлээлцэх” жагсаалтаар архивт хүлээн авч хаягжуулж, хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршуулан ажилласан байна.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй орсон болон огт ороогүй иргэдийн мэдээллийг санд тусгуулахаар архивын цаасан суурьт эх нотлох баримтаас хуулбарлан “Архиваас олгосон хуулбарын бүртгэл” хөтлөж ХУУЛБАР ҮНЭН тэмдэг даран нийт 71 иргэний бүртгэл мэдээллийг улсын бүртгэгч, Б.Бямбадулам, С.Сэржготов нарт хүлээлгэн өгсөн байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/17 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй 2017 оны ИУБ-22 маягт-6944 ширхэг, 2018 оны ИУБ-22 маягт-4537 ширхэг, 2018 оны ИУБ-21 маягт 5333 ширхэг, 2019 оны ИУБ-21 маягт-4371 ширхэг нийт 21185 ширхэг иргэний улсын бүртгэлийн баримтыг /ИУБ/ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн нэгдсэн архивын “Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс”-ын дүрмийг баримтлан 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 16 цаг 35 минутанд устгалыг хийж дуусгасан. Устгасан тухай тэмдэглэл, акт, баримтжуулсан фото зураг зэргийг хэлтсийн 2020 оны 09 дүгээр 22-ны өдрийн 1/1018 тоот албан бичгээр, мөн t.baigalmaa@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлж ажиллалаа.


Журмын дагуу сар бүрийн 25-ны өдөр иргэний бүртгэлийн архивын мэдээг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивт жилийн эцсийн байдлаар 11 удаа хэлтсийн даргын албан тоотоор хүргүүлсэн байна.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд нийт 117888 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийт **18518** иргэний улсын бүртгэл бүртгэсэн ба уг бүртгэлүүдийг мэдээллийн санд бүрэн тусгаж, баталгаажуулан ажиллалаа.

Иргэний бүртгэлийн төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:




Иргэний улсын бүртгэлийн мэдээ тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж ажиллалаа. Тайлант хугацаанд Иргэний бүртгэлийн тасаг нь нийт 18518 бүртгэл бүртгэж улсын төсөвт 66.149.873 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Цахим архивын программыг өдөр тутамдаа бүрэн ашиглаж 62 удаагийн албан бичгээр 1200 орчим иргэний бүртгэлийн алдаа, зөрчлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд арилгуулахаар Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн иргэний эрхийг бүрэн хангаж ажиллалаа.

4.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **1254** өргөдөл хүсэлт хүлээн авч ажиллагаа хийснээр дараах **148** аж ахуйн нэгжүүдийн бүртгэлүүдийг шинээр хийж гүйцэтгэлээ. Графикаар харуулбал:



Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд өөрчлөлтийн **262** бүртгэлийг хийсэн байна. Үүнд:



Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас татан буугдсан 5 бүртгэл хийсэн байна. Үүнд: ХХК-1, Хоршоо-2, Нөхөрлөл-2 болно.


Улсын бүртгэлийн архив мэдээллийн сангийн баазаас холбогдох лавлагаа, мэдээллээр нийт **120** удаа үйлчилгээ үзүүлснээс иргэнд-6, Хуулийн этгээдэд-48, Төрийн байгууллагад-66 удаа үйлчилгээ үзүүлсэн байна.

Хуулийн этгээдийн дараах 11 салбар бүртгэгдсэн байна.

1. ХХК-5
2. БСБ-1
3. ТББ-3
4. ХЗХ-1
5. ХК-1

2020 оны 12 сарын 09-ний өдрийн байдлаар Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих болон цуцлах бүртгэл огт хийгдээгүй болно.

Хуулийн этгээдийн бүртгэлийн бусад төрлийн бүртгэл дараах байдлаар хийгдсэн байна.



Тайлант хугацаанд хийсэн бүртгэлийн үйл ажиллагааны үр дүнд 10 617 000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг орон нутгийн дансанд, үйлчилгээний хөлс болох 74 000 төгрөгийг байгууллагын орлогын дансанд тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

Мөн Аймгийн Татварын хэлтэст 2018-2020 онуудад Татан буугдсан аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг 2 удаа, Статистикийн хэлтэст 2020 оны 1 дүгээр улиралд шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг тус тус хүргэн ажилласан байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт **2221** ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар" 148 ширхэг шинэ хувийн хэрэг, "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар 614 ширхэг нотлох баримт материал хүлээн авч хувийн хэрэг тус бүрт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилт, хаягжуулалт хийж ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 2019 онд бүртгэл хийх явцад хөтлөгдсөн нийт 11 баримтыг холбогдох журамд заасан дагуу 2020 оны эхний улиралд багтаан архивт хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршуулан ажилласан байна.

4.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2018- 2020 онуудад Улсын бүртгэлийн багц шинэ хуулиудын үзэл баримтлал, зорилго, зарчмыг иргэд, төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтэд чухал ач холбогдол бүхий дагалдан гарах дүрэм, журмын төслүүдэд холбогдох саналуудыг хүргүүлэх, улмаар улсын бүртгэлийн үйлчилгээний болон эрх зүйн орчны шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Харин 2020 онд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл үнэн зөв байх зарчмыг ханган, хуулийн хүрээнд иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эд хөрөнгийн эрхийг хамгаалах, хуулийг гардан хэрэгжүүлэгч улсын бүртгэгч нарыг сургаж хөгжүүлэх, чадавхижуулах, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чадварыг сайжруулахад онцгойлон анхаарал хандуулан ажиллаж байна.

Тасаг нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрыг бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллээр хангаж, хууль хяналтын байгууллагуудад

хуулийн хүрээнд лавлагаа мэдээлэл гарган өгөх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

1.1. Хууль тогтоомж сурталчлан таниулах үйл ажиллагаа

Төрийн албаны тухай хууль болон Улсын бүртгэлийн багц хуулийг сурталчлан таниулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж, нэгдсэн, цэгцтэй ойлголт өгөх замаар хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэх, сахин биелүүлэх, улсын бүртгэгч нарын хууль хэрэглэх ур чадварыг сайжруулах чиглэлээр олон талт ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хөдөө сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг сурталчлан таниулах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар мэдлэг олгох чиглэлийн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн хэдий ч Ковидтой холбоотойгоор хөдөө сумдад ажиллах боломжгүй нөхцөл байдал бий болсон тул уг төлөвлөгөө хэрэгжиж чадаагүй болно.

Харин Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгддэг гэрээний эрхийг төрлөөр нь, агуулга, ач холбогдлыг нь тайлбарлаж таниулсан зурагт хуудас (иргэдэд зориулсан)-ын агуулгыг бэлтгэж хэвлэлтэд өгөөд байна. Хөдөө сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг хийхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний дагуу 2020 оны 06 дугаар сарын 2-ноос 4-ний хооронд Богд суманд ажиллаж **120** гаруй иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг танилцуулж биечлэн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ **102** бүртгэл хийж эрх зүйн туслалцаа үзүүлэв.

1.2. Улсын бүртгэгч нарыг чадавхижуулах чиглэлээр:

Улсын бүртгэлийн багц хуулийг зөв ойлгон хэрэглэх, хэрэгжүүлэхэд улсын бүртгэгч нарт өдөр тутамдаа ажлын байрны сургалт хийж мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахын зэрэгцээ тодорхой сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулсан байна. Тодруулбал, Тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам нь улсын бүртгэгч нарт дараахь сургалтуудыг орсон байна. Үүнд:

“Нотариатын тухай хууль”-д өөрчлөлт орсонтой холбогдуулан аргачилсан зөвлөмж боловсруулан улсын бүртгэгч нарт хүргүүлэв. Уг зөвлөмжөөр нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт хуулиар олгогдсон чиг үүрэг, эрх хэмжээ, нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт олгосон хувийн дугаар, тэдгээрийн албан хэрэгцээнд хэрэглэх тамга, тэмдэг, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын талаар танилцуулж, анхаарах зүйл, онцлогийн талаар тайлбарлан танилцуулсан болно.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хөтлөхөд анхаарах асуудал, бүртгэл хөтлөхөд гарч байгаа нийтлэг алдаа,

зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар аргачилсан зөвлөмж өгсөн сургалтыг 4 удаагийн 8 цагийн сургалтыг зохион байгуулав.

- “Хувь хүний хөгжил байгууллагын хөгжилд нөлөөлөх нь” сэдвийн хүрээнд “Хувь хүний болон байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудаа тодорхойлж SMART, SWOT шинжилгээгээр шинжлэх арга зүйд суралцах”, “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн оновчтой төлөвлөх, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлох аргачилал” дэд сэдвүүдээр 2 өдрийн 8 цагийн сургалтыг нийт улсын бүртгэгч нарт зохион байгуулав.

1.3. Хууль тогтоомжийг нэг мөр ойлгох хэрэглэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар:

“Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-д заасан Дундын мэдээллийн санд газар эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд газрын даамлуудаас гаргаж буй нийтлэг алдаа, анхаарах асуудал, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэглэх” аргачилсан сургалтыг аймгийн ГХБХХГ-ын сургалтын танхимаас онлайн сургалтыг бүх сумдын газрын даамлуудад 2019 оны 12 дугаар сарын 18-нд зохион байгууллаа. Мөн эдгээр асуудалтай холбогдуулан зөвлөмж, чиглэлийг боловсруулан Хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлээ.

Баянхонгор сумын Засаг даргаас 2020 оны 4 сарын 13-ны өдрийн 1/162 тоот албан бичгээр ирүүлсэн “Газрын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрын +5, -5 хэмжээний дотор дардас хэрэглэж бүртгэл хийнэ үү” гэсэн хүсэлтийг судлан, Хэлтсийн даргын 2020 оны 1/601 тоот албан бичгээр хууль тогтоомжийн хүрээнд хариуг өгч, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэглэхэд дөхөм болох үүднээс холбогдох хууль, журам, дүрмийг танилцуулав.

Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Нотариатын товчоотой хамтран сумдын нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт онлайн сургалтыг зохион байгуулсан ба уг сургалтаар “Улсын бүртгэлийн үйлчилгээний нотариатын гүйцэтгэх үүрэг”, “Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарын анхаарах асуудал” сэдвээр улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн хичээл орж, гарч буй нийтлэг алдаа, хүндрэл бэрхшээлийн талаар ярилцав.

1.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шалгалт

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хөтлөхдөө бүртгэл үнэн, зөв, бодитой байх хуулийн зарчмыг хангаж байгаа эсэх, хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэл хөтлөгдөж байгаа эсэхэд сар бүр тогтмол хяналт тавьж, буруу буюу алдаатай бүртгэгдсэн бүртгэлийг цаасан суурьт эх нотлох баримттай нэг бүрчлэн тулган шалгах, алдааг залруулах арга хэмжээг тухай бүрд шуурхай авч байна. Тодруулбал, цахим санд алдаатай, зөрүүтэй, буруу бүртгэгдсэн 204 хувийн хэрэг бүртгэлийг залруулахаар

Хяналтын улсын байцаагчийн 26 удаагийн дүгнэлтийг гаргуулж, цахим системд мэдээллийг засварлах, нөхөн скайнердах ажлуудыг хийж бүртгэл үнэн зөв байх зарчмыг ханган ажиллалаа.

Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын **2019 оны 7/9562 тоот албан бичгээр** ирүүлсэн чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд бүртгэлийн үйлчилгээний төрөл буруу сонгож бүртгэн цахимжуулсан гэх 12 хувийн хэргийг, мөн газрын даргын **2020 оны 7/1960 тоот албан бичгээр ирүүлсэн** чиглэлийн дагуу Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд анх удаа бүртгэхдээ цахим мэдээллийн санд газрын нэгж талбарын дугаар тусгаагүй алдаатай бүртгэсэн гэх 58 хувийн хэргийг нэг бүрчлэн цаасан суурьт эх нотлох баримттай тулган шалгаж, улмаар Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан цахим системд алдааг засаж, холбогдох тайланг заасан хугацаанд нь гарган Илтгэх хуудсаар танилцуулсан болно.

Хоёр. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар


1.1. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд (2019 оны 12 сарын 06-наас 2020 оны 12 сарын 05-ныг хүртэлх хугацаа) эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн **нийт 9445 мэдүүлэг** хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Үүнээс улсын бүртгэлд бүртгэгдсэн **9327 мэдүүлэг**, буцаасан 118 мэдүүлэг байна.

Улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт бүртгэлийг агуулгаар нь ангилвал;

1. Анхны бүртгэл


Тайлант хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл 240, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 434, газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл 1580, **нийт 2254 бүртгэл** хийгдсэн байна.



2. Гэрээний эрхийн бүртгэл


Худалдах, худалдах авах гэрээний бүртгэл 551, бэлэглэлийн гэрээний эрхийн бүртгэл 37, Өв залгамжлалын эрхийн бүртгэл 68, хамтран өмчлөгч өөрчлөгдөх эрхийн

бүртгэл 149, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 1, **нийт 806** бүртгэл бүртгэгдсэн байна.



3. Бусад бүртгэл

Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөлтийн бүртгэл 324, эд хөрөнгийн хаяг өөрчлөлтийн бүртгэл 185, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөлтийн бүртгэл 9, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөлтийн бүртгэл 23, газрын нэгж талбарын дугаар өөрчлөлтийн бүртгэл 1, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 21, урьдчилсан тэмдэглэл хийлгэх бүртгэл 3, урьдчилсан тэмдэглэл хүчингүй болгох бүртгэл 1, хувийн хэрэг хаах бүртгэл 10, **нийт 577 бүртгэл** бүртгэгдсэн байна.



4. Барьцааны эрхийн бүртгэл

Барьцаалбартай барьцааны эрхийн бүртгэл 833, барьцаалбаргүй барьцааны эрхийн бүртгэл 1651, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээний бүртгэл 78, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах гэрээний бүртгэл 330, барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 2365, **нийт 5257** бүртгэл бүртгэгдсэн байна.

5. Лавлагаа, хуулбар олгох бүртгэл

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа 109, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын лавлагаа 39, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтаас хуулбар олгох бүртгэл 21 удаа, **нийт 169** бүртгэл хийгдсэн байна.

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн **2047 гэрчилгээ** олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөө сумын иргэдэд газар дээр нь хүргэх ажлыг зохион байгуулахаар Хэлтсийн 2020 оны төлөвлөгөөнд тусгасан ба уг төлөвлөгөөний дагуу эхний Богд суманд 2020 оны 06 дугаар сарын 02-ноос 6 сарын 04-нийг дуусталх хугацаанд ажиллаж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим бүртгэлийн үйлчилгээг 102 иргэнд үзүүлж, 120 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөвлөгөө өгч эрх зүйн туслалцаа үзүүлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн журмын дагуу барьцааны эрхийг бүртгэхдээ барьцааны эрхийн үнийн дүнгээс хамаарч, өөрөөр хэлбэл, **50.000.000** сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй, мөн хэд хэдэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан барьцааны эрх, шаардах эрхийг улсын бүртгэлд бүртгэхдээ улсын ахлах бүртгэгч болон хэлтсийн даргаар хянуулан бүртгэлийг хийсэн байна. Тодруулбал, **153** удаагийн “Хэд хэдэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээ, ипотек болон шаардах эрх шилжүүлэх гэрээг улсын бүртгэлд бүртгэх хяналтын хуудас”-аар **385** үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх болон шаардах эрх шилжүүлэх гэрээ хянагдан бүртгэгдсэн байна.

Хаягжуулалтын тухай хуулийн дагуу олгогдсон газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн шинэчилсэн хаягийн бүртгэлийг өдөр тутамдаа хийж байгаа ба тайлант хугацаанд нийт 744 үл хөдлөх эд хөрөнгийн хаяг өөрчлөлтийн бүртгэл хийгдсэн байна. Мөн уг хаягийн өөрчлөлтийн бүртгэлийн мэдээг сар бүрийн 25-30-ны хооронд Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газарт edkhourungu@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлдэг болно.

Дундын мэдээллийн санд ирсэн мэдүүлэг, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэдэг хэдий ч газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, газрын даамлууд бичиж олгосон гэрээ, гэрчилгээгээ буцаан хийдэггүй асуудал үргэлж байсаар байна. Энэ асуудлыг даруй шийдвэрлэх, гэрээ гэрчилгээг шуурхай оруулж байхад анхаарч ажиллах талаар Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2 удаа албан бичгээр хандсаны дүнд Дундын мэдээллийн санд ороогүй байсан 500 гаруй хувийн хэргийн гэрээ, гэрчилгээний дөнгөж 50 хувь нь Дундын мэдээллийн санд хийгдсэн байна. Мөн энэ тухай Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт edkhourungu@burtgel.gov.mn хаягаар танилцуулсан болно.

Дундын мэдээллийн сантай холбоотой гарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт edkhourungu@burtgel.gov.mn хаягаар 2 удаа хүсэлт илгээв. Мөн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргад газрын зориулалт төрлийг нэмэгдүүлэх, оновчтой нэршил өгөх, үүнийгээ газрын кадастрын программдаа нэмж оруулах талаар төв байгууллагадаа уламжилж шийдвэрлүүлэх саналыг илэрхийлэхийн зэрэгцээ улмаар хуулийн хүрээнд харилцан ойлголцолд хүрлээ.

Хууль хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэхь заалтыг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн хөдөлгөөн түдгэлзүүлсэн, өмчлөх эрхийг хязгаарласан бүртгэл 16, эрх сэргээсэн буюу битүүмжлэлээс чөлөөлсөн бүртгэл 4, эрх хязгаарлах, мөн хөдөлгөөн түдгэлзэх бүртгэлээс татгалзсан бүртгэл 2 хийгдсэн байна.

4.4. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архив:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 2020 оны жилийн байдлаар нийт **19827** ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс:

- Үл хөдлөх-7977
- Газар-9436
- Газар эзэмших, ашиглах эрх-2414

Жилийн эцсийн байдлаар нийт **8643** ширхэг бүртгэл, маягтыг хүлээн авсан байна. Үүнээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэл хийгдсэн шинэ хувийн хэрэг 2028, үйлчилгээ хийгдсэн /А,Б-1,2/ буюу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн маягт, нотлох баримт 6615 ширхэгийг эд хөрөнгийн тасгийн дарга, улсын бүртгэгч нараас бүртгэлийн нотлох баримт, шинэ хувийн хэргийг архивт хүлээн авахдаа “Архивт хүлээлгэн өгөх бүртгэлийн дэвтэр”-ээр хүлээн авч нэг бүрчлэн хувийн хэрэгт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан байна.

Мэдээллийн санд хувийн хэргийн дугаарлалт, үйлчилгээний төрөл зөрүүтэй орсон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардлагатай хувийн хэргийг Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, Хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нараас “Архиваас хувийн хэрэг захиалах хуудас”-аар захиалга авч нийт 512 хувийн хэрэг гаргаж, буцаан хүлээн авч хувийн хэрэг гарсан болон хүлээн авсан он, сар, өдрийг бүртгэн захиалгын хуудсыг хаалт хийн хувийн хэргийг санд буцаан байршуулсан байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэгч нараас 2019 онд бүртгэл хийхэд хөтлөгдсөн нийт 15 ширхэг баримтыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршуулж ажилласан байна.

ТАВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагчид нь Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам болон бусад эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах үйл ажиллагаа хийж гүйцэтгэсэн байна.

Нэг. 2020 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар бүртгэлийн төрөл тус бүрт хяналт тавьсан байдал.

- Иргэний бүртгэлийн чиглэлээр **28888**
- Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр **477**
- Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр **149**
- Архивын чиглэлээр **434** бүртгэлд хяналт тавьж, нийтдээ **29948** бүртгэлд хяналт тавьсан байна.

Хоёр. Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр илрүүлсэн зөрчил. Иргэний бүртгэл -225, Эд хөрөнгийн чиглэлээр 141, Хуулийн этгээд -7, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр -20 **Нийт 393** зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллалаа.

Гурав. Зөрчлийн тухай хууль. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт 1302 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс 1260 иргэн, 6 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулж, улсын төсөвт 32150000 төгрөгийн орлого оруулж, харин **36** иргэний өргөдлийн материалыг **татгалзаж** шийдвэрлэсэн байна.

Дөрөв.Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.

2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар гаргасан Хяналтын улсын байцаагчийн нийт **233** дүгнэлт гаргаснаас иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан дүгнэлтүүдийг хүснэгтээр харуулвал. Үүнд:

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Нөхөн бүртгэх тухай	4
2	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	74
3	Бүртгэл хийх тухай	1
4	Бүртгэл хүчингүй болгох тухай	40

5	Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай	25
6	Зөрчил арилгах тухай	57
7	Лавлагаа олгох тухай	2
8	Эд хөрөнгийн бүртгэлийн талаар	26
9	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	4
	Нийт	233

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Иргэний бүртгэл	203
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	4
3	Эд хөрөнгө	26
	Нийт	233

Зургаа. Хяналтын улсын байцаагчаас гарсан шийдвэр

№	Хяналтын улсын байцаагчийн	тоо
1	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	233
2	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсаар	1262
3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	Нийт	1495 ш

Тав. 2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс байгууллагын бичиг хэрэгт ирүүлсэн **нийт 281** өргөдөл, гомдол хүлээн авснаас 166 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, 3 өргөдлийг албан тоотоор, 7 өргөдлийг шийдвэрлэхээр шалгаж байна. Харин дүгнэлт гаргах шаардлагагүй 7 өргөдлийг холбогдох албан тушаалтан улсын бүртгэгч нарт шилжүүлэн шийдвэрлүүлсэн.

Мөн байгууллагын /тус хэлтсийн/ эрх бүхийн албан тушаалтны 47, иргэдээс ирүүлсэн **779** хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Зургаа. Иргэний улсын бүртгэлийн газраас чиглэл ирүүлсний дагуу 2019 оны 12 сард Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Нэг хаягт 10- аас дээш иргэн бүртгэлтэй” хаягийн мэдээллийг шалгах ажилд хэлтсийн албан хаагчид хамтран ажилласан ба тус ажлын хүрээнд ХУБ Л.Мэндбаяр 4, 5 дугаар, С.Баярмаа 7, 9 дүгээр багийн нутаг дэвсэрт хаягийн мэдээллийг шалгах ажлыг гардан хийсэн болно.

Долоо. 2020 онд хэлтсийн бүртгэлийн хяналтын нэгжээс Хяналт шалгалтын газар, Хууль, эрх зүйн хэлтэст санал хүргүүлсэн болон сумдын улсын бүртгэгч нарт чиглэл өгсөн ажлын талаар

1.Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 4/1280 тоот “Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”–иудыг хэрэгжүүлэх явцад тохиолдож буй хүндрэл бэрхшээлийн талаарх саналаа ирүүлэх тухай албан тоотод тогтоосон хугацаанд нь /2 санал/ хүргүүлсэн.

2.Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр нь 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Баянхонгор аймгийн сумдын улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэл хөтлөхтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн зарим зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлж анхаарах асуудлаар 01 тоот чиглэлийг бичгээр, хэлтсийн хаалттай группээр 2 удаа тус тус хүргүүлж ажилласан байна.

3.Иргэний улсын бүртгэл хөтлөхтэй холбоотойгоор иргэний улсын бүртгэгчдэд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч нар, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга нарын хамтарсан чиглэлийг хүргүүлсэн.

4. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Хяналт шалгалтын газарт дараах санал асуулга хүргүүлсэн байна. Үүнд:

1.Зөрчилд хөөн хэлэлцэх тооцох эсэх

2.Ямар зөрчилд хөөн хэлэлцэх хугацаа тооцох болон тооцохгүй байх.

3.Зөрчлийн тухай хуульд хуульчлагдаагүй үйлдэлд шийтгэл ногдуулж болох эсэх /эрх зүйн зохицуулалт тодорхойгүй/ зэрэг болно.

2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газар болон Аймгийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэлтийн мэдээг тус тус 11 удаа хугацаанд нь хүргүүлсэн, мөн зөрчлийн материалыг 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагуудад хүргүүлж /11 удаа/ хянуулан ажиллалаа.

Найм. Бүртгэлийн хяналтаас хийж хэрэгжүүлэх бас нэг ажил бол анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих ажил бөгөөд тайлант онд 2020 онд 3 сарын 31-ний өдөр Эрдэнэцогт суманд ажиллаж 2019 оны төрөлтийн 84 бүртгэлийн нотлох баримт, шилжилт хөдөлгөөний 20 бүртгэлийн нотлох баримт үнэт цаасыг мэдээллийн санд тулган шалгаж илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Мөн Галуут суманд 11 дүгээр сарын 3-ны өдөр ажиллаж 2020 онд бүртгэгдсэн төрөлтийн 87 бүртгэл, шилжилт хөдөлгөөний 44, гэрлэлтийн 14, гэрлэлт цуцлалтын 2, үрчлэлтийн 2, овог, эцэг, эхийн нэр өөрчлөлтийг 7, нас барсны 14, эцэг тогтоолын 5, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн 214 бүртгэлийн эх нотлох баримт, бүртгэлийн дэвтрийг мэдээллийн санд тулган шалгаж дэвтэр дутуу хөтөлсөн, өргөдөлд гарын үсэг зураагүй зөрчлүүдийг газар дээр нь арилгуулж ажиллалаа. Хүрээмарал суманд 10 сарын 16-ны өдөр ажиллаж Зөрчлийн тухай хууль болон Улсын бүртгэлийн багц

хуулиудаар мэдээлэл хийж хугацаа хэтрүүлсэн 2 зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч газар дээр нь хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн болно.

ЗУРГАА. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН САЙЖРУУЛАЛТ;

6.1. Программ хангамжийн талаар:

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох нь” төслийг 2018 оноос Улсын Бүртгэлийн ерөнхий газар үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн.

Уг төслийн хүрээнд 2018, 2019 онд Галуут, Богд, Баян-Өндөр, Баян-Овоо, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр, Шинэжинст, Баянцагаан, Баацагаан, Жинст, Эрдэнэцогт зэрэг сумдыг онлайн сүлжээнд холбосон бол 2020 оны 08 дугаар сарын 24-26-ны өдөр Баянлиг болон Баянговь сумдыг бүртгэлийн онлайн сүлжээнд холбох ажлыг амжилттай хийж гүйцэтгэв. Онлайн сүлжээний тусламжтайгаар харъяалал харгалзахгүй бүртгэлийн үйлчилгээг сумаасаа авах боломж бүрдэж байгаа юм. Ингэснээрээ бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргээд зогсохгүй иргэдийн цаг хугацаа болоод эдийн засгийг хэмнэх, Улсын Бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг ойртуулах зэрэг ач холбогдолтой.

УБЕГ-аас иргэний улсын бүртгэлийн шинэчилсэн программыг ажиллагаанд оруулж сумдын улсын бүртгэгчид дадлага хийн ажиллаж холбогдох санал болон дадлага хийсэн тайланг илтгэх хуудсаар хүргүүлсэн ба энэ талаар тус тайлангийн Чиглэл, үүрэг даалгаврын биелэлт хэсэгт бичсэн болно.

Хэлтсээс бүртгэлийн үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангаж энэ онд цөөнгүй саад бэрхшээлтэй байдлыг түргэн шийдвэрлэж ажиллалаа. Дурдвал: Жаргалант, Бууцагаан, Гурванбулаг, Жинст, Баян-Өндөр сумдын онлайн программтай зөөврийн компьютерын хард диск, онлайн программ болон зургийн аппарат гэмтэх, систем гэмтэх гэх мэт гэмтлүүдийг цаг алдалгүй түргэн шуурхай засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн хэлтсийн нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтнуудын компьютерийн үзүүлэлт болон хард диск гэмтэж улмаар УБЕГ-ийн санхүү хэлтсээс шинээр сольж систем суулган хэрэгцээт программуудыг суулган өглөө.

Техник, тоног төхөөрөмжийн талаар:

2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтэст Баянхонгор аймгийн Засаг дарга болон түүний ажлын алба, хэлтсийн дарга нар ирж хэлтсийн байр болон үйл ажиллагаатай танилцаж ажилласан. Аймгийн Засаг даргад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч У.Золзаяа санал тавьж хэлтсийн иргэний улсын бүртгэгч, архивч нарын 4 албан хаагчийн үйл ажиллагаандаа хэрэглэдэг

компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага хангахгүй, хугацаа дууссан талаар танилцуулж хүсэлт тавьсны үр дүнд 2020 оны 03 дугаар сард аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасагт иж бүрэн 4 шинэ компьютер, 3 үйлдэлтэй 1 ширхэг конан /скайнер, принтер/ хүлээлгэн өгч улсын бүртгэлийн ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж дэмжлэг үзүүлэн ажилласан. Өнөөдрийн байдлаар аймгийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн 1 улсын бүртгэгч, 1 архивч, улсын ахлах бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан нийт 4 албан хаагч тоног төрөөрөмжөө шинэчлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн УБЕГ-т хүсэлт тавьж нягтлан бодогчид зөөврийн компьютер 1 ширхэг, УБЕГ-аас хурдны скайнер “canon 6010”-ыг эд хөрөнгийн бүртгэгчид, Баянговь сумын улсын бүртгэгчид canon 1000D маркын зургийн аппаратыг тус тус шинээр авч үйлчилгээндээ ашиглаж байна.

Харин Баянцагаан сумын улсын бүртгэгчийн canon 1000D маркын зургийн аппаратны USB залгуур гэмтсэнийг УБЕГ-ын санхүүд мэдэгдэж олгуулах шийдвэрийг гаруулаад байна.

Тайлант хугацаанд бүртгэлийн сүлжээ гацах, тасрах ажиллахгүй байх зэрэг хүндрэлүүд цөөнгүй гарсан ба тухай бүр нь холбогдох байгууллага хүмүүстэй холбогдож үйл ажиллагааг хэвийн болгон ажилласан.

Баянлиг болон Баянговь сумдын сүлжээний media converter-ууд шатаж Азийн хөгжлийн банкны төслийн зохицуулагчтай холбогдож 2 ширхэг media converter авч тухайн сумдад очиж төхөөрөмжийг сольж ажиллагаанд оруулсан.

Хэлтсийн албан үйл ажиллагаад ашигладаг интернет сүлжээг МИКОМ ХХК –аас дамжуулан авч байсны салгаж UNIVISHION ХХК-аас энэ оны 10 сард холболт хийлгэн ашиглаж байна.

ДОЛОО. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 оны 12 сарын 15-ны байдлаар улсын төсвөөс 536.450.9 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 403.530.8, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 58.071.1, гэрэл цахилгааны зардалд 2.570.7, түлш халаалтын зардалд 40.602.8, цэвэр бохир усны зардалд 1.924.3, бичиг хэргийн зардалд 7.324.7, тээвэр шатахууны зардалд 1.652.7, шуудан холбооны зардалд 2.652.7, хог хаягдал зайлуулах зардалд 181.4, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1.480.5, багаж техник хэрэгслийн зардалд 671.4, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 243.9, урсгал засварын зардалд 88.0, дотоод албан томилолтын зардалд 72.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 187.0, аудит баталгаажуулалтын зардалд 300.0, даатгалын зардалд 280.0, тээврийн хэрэгслийн татварын зардалд 148.5, тээврийн хэрэгслийн оношлогооны зардалд 22.0, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 200.0, 2020 оны УИХ-ын сонгууль, Аймаг. Нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулиар

170.914.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 170.875.6 мянган төгрөг зарцуулж ажилласан. УИХ болон Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн ажлын хүрээнд УИХ-аар 114, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аар 106 хэсгийн хороонд ажиллах итгэмжлэгдсэн ажилтны цалин урамшуулал, томилолт замын зардал, шатахуун, холбоо, бичиг хэргийн зардлыг зарцуулж алдаа зөрчилгүй ажилласан. Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын байгууллагаар сонгуулийн зардлын зарцуулалтыг хянуулж ажилласан.

Үндсэн үйл ажиллагааны орлого 171.8 сая төгрөгийг сар бүрийн эцэст улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газраас 16.766.5 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материалыг хүлээн авч 5.842.8 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материалд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч хэвшсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар улирал, хагас жилийн тайланг УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газарт сар бүр, Татварын хэлтэст улирал бүр тайланг мэдээг хуулийн хугацаанд нь гаргаж баталгаажуулан харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж өглөг авлага үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.

Байгууллагын 2022 оны төсөв, 2023-2024 оны төсвийн төсөөллийг 2020 оны 06 сарын 22-ны өдөр УБЕГ-т хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан 133 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 11 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2019 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн Аудитын байгууллагаар шалгагдаж ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Засгийн газрын тогтоолын дагуу ТАЦНС-д нэвтэрч байгаатай холбоотойгоор зохион байгуулсан сургалтад идэвхитэй хамрагдаж Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээллийг үнэн зөв оруулж 2020 оны 07 дугаар сараас эхлэн байгууллагын албан хаагчдад ТАЦНС-ээр дамжуулан цалинг бодож олгож байна.

НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА

8.1. Байгууллагаас зохион байгуулсан ажил, үйлчилгээ

Байгууллага хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахаас гадна байгууллагын дотоод үйл ажиллагааг иргэд үйлчүүлэгчдэд байнга сурталчлах шаардлагатай байдаг. Энэ шаардлагын үүднээс хэлтсийн <http://bkh.burtgel.gov.mn/>, <https://bayankhongor.burtgel.gov.mn/> сайт болон байгууллагын facebook page хуудсуудаар дамжуулан иргэдэд байгууллагаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байна.

Мөн бүртгэлүүдийн талаар шинэ гарын авлага, мэдээ мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай хэлтсийн байрны мэдээллийн самбарууд үүдний гонхонд сурталчилгааны зурагт хуудсуудын эхийг бэлтгэн шинэчлэн байрлуулан ажиллаж байна. 2020 оны 12 дугаар сарын 09-ний байдлаар <http://bkh.burtgel.gov.mn/> сайтад 58 мэдээ мэдээлэл <https://bayankhongor.burtgel.gov.mn/сайтад> 25 мэдээ мэдээлэл нийт 83, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс face book page хуудсанд **184** мэдээлэл тавьж ажилласан байна.

Дэлхий даяар үүсээд буй шинэ төрлийн корона вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж заавар, хэлтсийн ажиллах цагийн хуваарь, лавлагаа мэдээлэл авах утасны дугаар, цахимаар авч болох бүртгэлийн үйлчилгээ, нийт хийсэн бүртгэлийн тоон үзүүлэлт зэрэг бусад мэдээ мэдээллийг түргэн шуурхай байршуулж түгээн дэлгэрүүлж ажиллалаа. Жишээлбэл: **Корона вирусээс урьдчилсан сэргийлэхтэй холбоотой хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулсан 2 минутын видео шторк бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээсэн.**

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж, шэйр хийж хөл хорио тогтоосон онцгой дэглэмийн үед идэвхтэй ажиллах үүргийг өгч ажиллалаа.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс болон Санхүү, төрийн сангийн хэлтэс, Аймгийн Эрүүл мэндийн газрын холбогдох албан хаагчид, 20 сумын эргэлтийн эмийн сангийн эрхлэгч нарт 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ОНӨААТҮГ-ын газрыг хэрхэн байгуулах талаар арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан болно.

Орон нутгийн “Hongog TV” телевизээр УБЕГ-ын сайтад байршуулсан Сонгогчийн нэрийн жагсаалтаас өөрийн мэдээллийг шалгах шторкийг цацуулж олон нийтэд түгээсэн.

Иргэдэд 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Баянхонгор аймгийн “Баянхонгор телевиз”-ээр, “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн тухай ойлголт, түүнийг бүртгүүлэх эрх зүйн үндэслэл, улсын бүртгэлд хэрхэн бүртгэх” талаар зөвлөгөө мэдээллийг **ТВ-9 телевизээр** тус тус өгч ажиллалаа.



8.2. Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан

Хэлтсийн хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 14-ны байдлаар ирсэн албан бичиг **895**, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж, дотоод албан бичиг **102** тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс **1284** албан бичиг явуулсан байна.

Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж **Able** программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.

Хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагаас ирсэн хариутай албан бичиг **665** ба хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно.

Удирдлагаас гарах шийдвэр болоод зохион байгуулалтын баримт бичиг 31 байна, үүнээс Хэлтсийн даргын тушаал 26, хамт олны хурлын тэмдэглэл 4, баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлын тэмдэглэл 1 гарсан байна.

2020 оны байгууллагын “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-д тусгуулах шаардлагатай Бүртгэлийн үйл ажиллагааны явцад шинээр бий болсон баримт материалын нэрийн саналыг албан хаагч тус бүрээс авч 2 дугаар сарын 07-ны өдөр тус комисс хуралдаж 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж ажиллалаа.

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд **нийт 214 өргөдөл, гомдол, хүсэлт** ирсэн байх ба үүнээс шийдвэрлэгдсэн 177, хугацаа болоогүй 35, хугацаа хэтэрч 2 шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байна.

Мөн ирсэн өргөдөл, гомдлыг **Able** программ дээр болон өргөдөл, гомдлын дэвтэр дээр бүртгэн хяналтын картыг хөтлөж байна.

Өргөдлийг агуулгаар нь авч үзвэл зэрэг дэв, цалингийн шатлал нэмэгдүүлэхийг хүссэн өргөдөл 11, хүүхэд асрах болон цалинтай чөлөө хүссэн өргөдөл 3, ажилдаа эргэн орохыг хүссэн өргөдөл 1, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 3, ажил хавсран гүйцэтгэсэн урамшуулал болон тэтгэмж хүссэн тухай өргөдөл 5, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой 9, иргэний бүртгэлийн зөрчлийг арилгуулах, зөрчилтэй бүртгэлийг залруулах, бүртгэл хүчингүй болгуулах, нөхөн бүртгүүлэх зэрэг Хяналтын улсын байцаагчид шалгуулах шаардлагатай өргөдөл 175, лавлагаа авах 3, бусад 4 өргөдөл байна.

Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 15-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт албан бичгээр болон цахим хаягаар хүргүүлсэн.

ЕС. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДИЙН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ

9.1. Албан хаагчдын сургалт, хөгжил

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд 2020 оны хагас жилийн байдлаар доорх байдлаар сургалт мэдээллийг хийж ажиллалаа.

- 1 дүгээр сарын 8-ны өдөр Татварын хэлтсийн татвар төлөгчдийг хариуцсан мэргэжилтэн Б.Энхсүвд “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулиар

-1 дүгээр сарын 15-нд Хэлтсийн дарга -Цаг үеийн асуудал, хамт олны яриаг хийж үйлчилгээний стандартыг чанд мөрдөж ажиллах талаар.

- 1 дүгээр сарын 22-нд Эрүүл мэндийн сургалт зөвлөгөө

- 1 дүгээр сарын 23-нд Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгийн мөрдөгч Б.Иса “Залилах гэмт хэрэг” Ятгах тусам нягтал сэдвээр сургалт мэдээлэл.

-1 дүгээр сарын 27-нд Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж сэдвээр –“Шинэ хүн” эмнэлгийн сувилагч Ц.Эрдэнээ

-1 сарын 29-нд Хяналтын улсын байцаагч С.Баярмаа – “Архины хор хөнөөл” сэдвээр сургалт хийсэн.

-2 сарын 5-ны өдөр- Хэлтсийн дарга цаг үеийн мэдээлэл, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаар ирүүлсэн чиглэл зөвлөмжийг танилцуулав.

-2 сарын 19-ны өдөр хэлтсийн дарга цаг үеийн мэдээлэл хийсэн.

Ерөнхий газраас зохион байгуулсан 12 удаагийн онлайн сургалтад холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан. Дурьдвал:

- Хуулийн этгээдийн бүртгэгч нарын сургалт- 1 сарын 4

-УБЕГ-ын мэргэжилтэн Т.Наранцэцэгийн ЭБАТ-уудын сургалт

- 2020 оны 03 сарын 06-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан онлайн сургалт “УИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах” онлайн сургалт

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт - /3 сарын 23/

-Бичиг хэргийн ажилтнуудад зориулсан сургалт -4 сарын 17

-Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт -4 сарын 30

-2020 оны 05 сарын 06-08-ны өдрүүдэд Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэх арга зүй сэдэвт лекц болон практик сургалтанд.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт -05 сарын 26

Хэлтсийн хэмжээнд шинээр онлайнд холбогдсон сумд болон бусад сумдын иргэний улсын бүртгэгч нарт 2020 оны 01-03 дугаар сарын хооронд танхимын сургалт 2 удаа, онлайн сургалт 3 удаа зохион байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуультай холбогдуулан 114 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг 2020 оны 05 дугаар сард онлайнаар 1 удаа, эрх зүй, мэдээлэл технологийн сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан.

Харин 2020 оны сүүлийн хагаст дараах байдлаар сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан болно.

-Улсын бүртгэлийн хэлтэс нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн Улсын бүртгэлийн байгууллагын 106 итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан хууль эрх зүйн цахим сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 15 - ны өдөр онлайнаар зохион байгуулав.

-Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх цогц ажлын хүрээнд хэлтсийн хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярыг “Эрх зүйн хөтөч бэлтгэх” 16 цагийн сургалтанд хамруулж гэрчилгээ авсан ба албан хаагчид, иргэдэд эрх зүйн мэдээлэл, сургалтыг үр дүнтэй зохион байгуулж явуулж байна.

- Мөн Хяналтын улсын байцаагч С.Баярмаа “Иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн зөрчил, цаашид анхаарах асуудал”, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр тус тус сургалт зохион байгуулан ажиллалаа.

-Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-аас орон нутаг дахь Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудыг хууль эрх зүйн мэдээллээр хангах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжтай ажиллах дадлага сургуулилтыг Баянхонгор аймагт 10-р сарын 05-ны өдөр зохион байгуулж байна. Тус сургалт, дадлага сургуулилтад 106 итгэмжлэгдсэн ажилтан бүрэн хамрагдав.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжаар батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх жилийн аян”-ыг эрчимжүүлэх, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор зохион байгуулагдсан “Сархадаас сална аа хө” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд “Тархины вакцин” сургалт зохион байгуулагдаж хэлтсийн ажилтан, албан хаагчид оролцож, аймгийн Цагдаагийн газрын Сэтгэл зүйч, ахлах дэслэгч Д.Хоролгарав, Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмч Б.Мөнхсүлд нар сэтгэцийн эрүүл мэнд, стрессийг хэрхэн даван туулж, ангижрах, архины зүй зохистой хэрэглээ, архины хор хөнөөл, нөлөөлөл, хорт зуршлаас өөрийгөө хэрхэн хамгаалах вэ? зэрэг сэдвүүдээр лекц орлоо.



Хэлтсийн даргаас санаачлан 5 иргэний улсын бүртгэгчийг Глобал удирдагч дээд сургуулийн эрх зүйн эчнээ ангид суралцуулахаар гэрээ байгуулснаар 2020 оны 10 дугаар сарын 17-аас эхлэн Баянхонгор аймагт тус сургуулиас хичээлийг эхлүүлэн амжилттай суралцаж байна.

9.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг ямагт биднээс шаардаж байдаг.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцааны хандлагыг өөрчлөх, байгууллагын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор үйлчилгээний зааланд санал хүсэлтийн дэвтэр, өргөдөл гомдол хүлээн авах 89191901 утсыг тогтмол ажиллуулж байна.

Одоогийн байдлаар ёс зүйн алдаа зөрчил гаргаж хариуцлага хүлээсэн албан хаагч байхгүй болно.

МУИХ, ЕТГ,ТАЗ,НҮБХХ, КУЭСЯ-тай хамтран Итгэл даах төрийн албаны төлөө уриан дор "Төрийн албаны шинэчлэл ба ёс зүйн хандлага" улсын нэгдсэн зөвлөгөөнийг улс орон даяар 2020 оны 09 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд цахимаар зохион байгуусан ба Улсын бүртгэлийн хэлтсийн сумдын иргэний улсын бүртгэгчид сумаасаа, хэлтсийн дарга байгууллагын ёс зүйн зөвлөлийн төлөөллийн хувиар тус зөвлөгөөнд оролцлоо.

АРАВ. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

10.1. Орон нутаг дахь төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа

Аймгийн Засаг дарга 2020 оны шинэ оны ажлаа байгууллагын үйл ажиллагаатай танилцах зорилгоор Улсын бүртгэлийн хэлтсээс эхлүүлсэн бөгөөд энэ үеэр Аймгийн Засаг даргад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч У.Золзаяа санал тавьж хэлтсийн иргэний улсын бүртгэгч, архивч нарын 4 албан хаагчийн үйл ажиллагаандаа хэрэглэдэг компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага хангахгүй, хугацаа дууссан талаар танилцуулж хүсэлт тавьсаны үр дүнд 2020 оны 03 дугаар сард аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасагт иж бүрэн 4 шинэ компьютер, 3 үйлдэлтэй 1 ширхэг конан /скайнер, принтер/ хүлээлгэн өгч улсын бүртгэлийн ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж дэмжлэг үзүүлэн ажилласан.



“Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-д заасан Дундын мэдээллийн санд газар эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд газрын даамлуудаас гаргаж буй нийтлэг алдаа, анхаарах асуудал, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэглэх” аргачилсан сургалтыг аймгийн ГХБХХГ-ын сургалтын танхимаас онлайн сургалтыг бүх сумдын газрын даамлуудад 2019 оны 12 дугаар сарын 18-нд зохион байгууллаа. Мөн эдгээр асуудалтай холбогдуулан зөвлөмж, чиглэлийг боловсруулан Хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлээ.

Баянхонгор сумын Засаг даргаас 2020 оны 4 сарын 13-ны өдрийн 1/162 тоот албан бичгээр ирүүлсэн “Газрын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрын +5, -5 хэмжээний дотор дардас хэрэглэж бүртгэл хийнэ үү” гэсэн хүсэлтийг судлан, Хэлтсийн даргын 2020 оны 1/601 тоот албан бичгээр хууль тогтоомжийн хүрээнд хариуг өгч, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэглэхэд дөхөм болох үүднээс холбогдох хууль, журам, дүрмийг танилцуулав.

Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Нотариатын товчоотой хамтран сумдын нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт онлайн сургалтыг 2020 оны 4 дүгээр



сард зохион байгуусан ба уг сургалтаар “Улсын бүртгэлийн үйлчилгээний нотариатын гүйцэтгэх үүрэг”, “Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарын анхаарах асуудал” сэдвээр улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн хичээл орж, гарч буй нийтлэг алдаа, хүндрэл бэрхшээлийн талаар ярилцав.

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн салбар хороодын бүрэлдэхүүнд зохион байгуулсан цахим сургалтанд хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал оролцож Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам сэдвээр мэдээлэл хийж хамтран ажиллалаа.

10.2. Аймаг, орон нутгаас зохион байгуулж буй бусад үйл ажиллагаанд оролцсон байдал

-Монгол улсын ЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ корона вирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэх тухай” А/44 дүгээр захирамж, мөн өдрийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” А/45 дугаар захирамж, 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллах тухай” А/104 дүгээр захирамж, Аймгийн Онцгой комиссын хуралдааны шийдвэр түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан аймгийн Засаг

даргын 2020 оны захирамжуудын хэрэгжилтийг хангаж тус хэлтсийн албан хаагчид Баянхонгор сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 15-нд хөдөлгөөнт эргүүлийн үүргийг Баянхонгор сумын Гэгээн шавь 6 багийн нутаг дэвсгэрт гүйцэтгэв.

-Хол хориог сунгасантай холбоотойгоор мөн хэлтсийн албан хаагчид Баянхонгор сумын Засаг даргаас баталсан хуваарийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 20, 24, 28-нд мөн хөдөлгөөнт эргүүлийн үүргийг Баянхонгор сумын 2 багийн нутаг дэвсгэрт, 2020 оны 12 дугаар сарын 04-нд Баянхонгор сумын 1 багийн нутагт хөдөлгөөнт эргүүлийн үүргийг гүйцэтгэж ажиглалтад байгаа иргэдийн гэрийн гадаа тус тус гүйцэтгэн ажиллалаа.



Харин хэлтсийн дарга 11 дүгээр сарын 26-ны өдөр Баянхонгор аймгийн төв тойрсон постын 3 дугаар цэгт 24 цагийн үүрэг гүйцэтгэж ажиллалаа.

-Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны А/01 тоот захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх аян зарлах тухай” захирамжийн хэрэгжилтийн хүрээнд тус аяны нээлтэнд хамт олноороо оролцож, архины хор уршгийг олон нийтэд таниулан, сурталчилсан зурагт хуудсыг бэлтгэн хэлтсийн албан хаагчид болон иргэдэд хэлтсийн цахим хуудсаар сурталчлан, ажлын тайланг сар бүрийн 20-ны өдөр гарган Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.



- Аймгийн онцгой комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хэлтсийн албан хаагчдын нэг өдрийн цалин 1.270.500 төгрөгийг хандивласан.



Мөн 12 дугаар сарын 02-ны өдөр аймгийн Онцгой комисст тус хэлтсийн хамт олны сэтгэлийн хандив 800000 /найман зуун мянга/ төгрөгийг хэлтсийн дарга гардуулан өглөө.



Баянхонгор аймгийн харъяа зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнд 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр холбогдох албан тушаалтнууд оролцлоо.



Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон "ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН БАЯНХОНГОР" аянд нэгдэж байгууллагын албан байрны орчим 50 м газар болон хэлтэст оноож өгсөн аймгаас баруун тийш чиглэлийн хот хоорондын замын ойролцоох газрын хог хаягдлыг цэвэрлэн аяны арга хэмжээнд ач холбогдол өгч Хонгор нутгийнхаа цэвэр орчинг бүрдүүлэхийн тулд идэвхитэй ажиллалаа.



Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан "Авлигагүй нийгмийн төлөө - 3 аян"-ы чөлленжид хэлтсийн албан хаагчид нэгдэж энэ талаарх мэдээлэл болон шторкуудыг хэлтсийн Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс пэйж хуудаст байршуулан сурталчилж ажиллав.

- ГБХЗХГ-аас зарласан “Гадаадад байгаа Монголчууддаа маскаар туслая” аяны хүрээнд 20 ширхэг маск хандивлав.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Бүх нийтээр мод тарих өдрөөр Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, ажлын байрны орчны тохижилт үйлчилгээг хийх зорилгоор хэлтсийн албан байр орчмын хог цэвэрлэгээг хийж хэлтсийн гаднах цэцгийн мандалд цэцгийн үр суулгаж, шинээр зүлэгжүүлэлт хийн, байгууллагын хариуцсан ойн



зурвас бүхий газарт тарьсан модыг арчлах, услах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дэлхийн хэмжээнд тархаад байгаа Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Үйлдвэрчний эвлэлийн хорооны зүгээс ажлын байрны өрөө тасалгаа болон үйлчилгээний зааланд ариутгал халдваргүйтгэлийн ажиллагааг Бурхантын эх ХХК-иар 2, “Номгон ариусал” ХХК-аар 3 удаа чанарын шаардлага хангасан ариутгалын бодисоор хийлгүүлж ажиллалаа.



Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу албан хаагчдын эрүүл мэнд, чийрэгжилтийг дэмжин ажиллаж 5 дугаар сарын 8, 22-ны өдрүүдэд ажилтнуудын бие бялдар, дасгал хөдөлгөөний сорилыг өгч, дасгал хөдөлгөөн хийсэн.



- **2020 онд** Монгол улсын Ерөнхийлөгч болон УИХ-ын даргын **Баянхонгор аймагт** албан ёсны айлчлалын үеэр зохион байгуулагдсан иргэд төрийн албан хаагчидтай хийх уулзалтанд хэлтсийн хамт олон бүрэн хамрагдав.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны А/01 тоот захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх аян зарлах тухай” захирамжийн хэрэгжилтийн хүрээнд архины хор уршгийг олон нийтэд таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх зурагт хуудсуудыг хийж бэлтгэн хэлтсийн фэйсбүк пэйж хуудсаар сар бүр бэлтгэн сурталчилж, албан хаагчдын дунд Архины эсрэг ухуулга сурталчилгааг сурталчилсан мэдээллээр асуулт сорилын шалгалтыг авах, ажилтнуудын дунд АХА тэмцээн зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулан явуулж сар бүрийн 20-ны өдөр хэрэгжилтийг илтгэх хуудсаар Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Хэлтсийн албан хаагчид архидан согтуурахтай холбогдсон гэмт хэрэгт холбогдоогүй болно.

Жил бүрийн 10 дугаар сарын сарын 01-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг “Дэлхий ахмадын өдөр”-ийг тохиолдуулан гавъяаны амралтандаа суусан албан хаагчдад Үйлдвэрчний хорооны зүгээс 150 000 төгрөгийн үнэ бүхий гарын бэлгийг бэлтгэн хүргүүлэв.

Дэлхийн хэмжээнд тархаад байгаа Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 3 удаагийн ажиллагаагаар Үйлдвэрчний эвлэлийн хорооны зүгээс хэлтсийн нийт албан хаагч тус бүрт 57 ш маск, гар ариутгагч-2,

витаминов-С-4 уут, бээлий- 4 хос, нүүрний хаалт -1 зэрэг дархлаа дэмжих болон хамгаалалтын хэрэгслийг тараан ажилласан.

Үйлдвэрчний эвлэлийн хорооноос дээрх ажиллагаануудад нийт 852500 төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газраас “Дэлхийн алхалтын өдөр”-т зориулан Албан байгууллагуудын дунд зохион байгуулсан 8 км зайн явган алхалтад оролцов. Мөн үеэр тус газраас “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” бүх нийтийн арга хэмжээний дүнг гаргахад хэлтсийн хамт олон идэвхтэй оролцож 3 дугаар байрт шалгарсан амжилтыг үзүүлэв.



АРВАН НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 80 ЖИЛИЙН ОЙГ УГТАЖ ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР

Тус хэлтсээс Ерөнхий газраас ирүүлсэн удирдамжийн хүрээнд нийт албан хаагчдаас санал авч “Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтаж хийх ажлын төлөвлөгөө” батлан хэрэгжүүлсэн билээ.

Уг төлөвлөгөөний дагуу 8 ажлыг хэрхэн хэрэгжүүлсэн тухай танилцуулъя.

1. Хэлтсийн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ба иргэдийн харилцаа” сэдвээр лекц уншуулах

-Байгууллагаас ажилтнууддаа оюуны хөрөнгө оруулалт хийхэд анхаарч ажилласан ба энэ онд Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ой тохиож буйг тохиолдуулан “Төрийн албан хаагч ба иргэдийн харилцаа”, “Хандлага таны амжилтын луужин” сэдвүүдээр шилдэг лекторуудыг урьж хамт олондоо 10 сарын 09, 11 сарын 05-ны өдөр тус тус лекс уншуулав.



2. Байгууллагын хуваарьт газар болон ойн зурвасын мод арчлах, хог хаягдалыг цэвэрлэх, аймгаас баруун чиглэлийн хот хоорондын замын хажуугийн 50 м газрын хог хаягдлыг цэвэрлэж иргэн төдийгүй байгууллага нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллалаа.



3. “Би шилдэг бүртгэгч” аян зарлах

Аяныг Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 10 дугаар сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 18-ны хооронд зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. Дүгнэх хугацаа хараахан болоогүй байгаа тул эцсийн байдлаар хэрэгжилт гараагүй болно.

4. Улсын бүртгэгчдийн дунд шилдэг гарын авлага, брошурын уралдаан зарлах

Уралдааныг 14 хоногийн хугацаатай зарлаж нийт 14 бүртгэгч брошур бэлтгэн ирүүлснийг болзлын дагуу дүгнэхэд Баацагаан сумын иргэний улсын бүртгэгч Ж.Оргилмаагийн бэлтгэн ирүүлсэн брошур шалгарсан болно.

5. 2021 онд шинээр биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлэх 2005 онд төрсөн хүүхдүүдийн иргэний улсын бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах “Зөрчилгүй бүртгэл аян” зохион байгуулах

Тус аяныг иргэний улсын бүртгэгч Б.Бямбадулам хариуцан гүйцэтгэж УБЕГ-аас 2005 онд төрсөн иргэдийн мэдээлэл бүхий баазыг татан авч ажиллагаа хийн ажилласнаар 2005 онд төрсөн 2021 онд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдаж шинээр иргэний цахим үнэмлэх авах иргэдийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тулган шалгаж архивын сангаас нийт 1403 иргэний хувийн хэргийг захиалгын хуудсын дагуу хүлээн авч ажилласан.

Зорилго нь: Бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэнд чирэгдэл үүсэх эрсдэлээс сэргийлэн 2021 онд 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр авах 2005 онд төрсөн 1403 иргэний хувийн хэргийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалган иргэний ургийн овог алдаатай орсон, хаяг ороогүй зэрэг зөрчилтэй 283 иргэний мэдээллийг засуулахаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Бусад

973 иргэний мэдээлэл алдаагүй, 146 иргэн өөр аймаг, нийслэл рүү шилжин явсан, 1 иргэн нас барсан байна.

6. Сумдад Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах

Уг ажил хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хэрэгжээгүй болно.

7. Шинэ төрсөн хүүхдийн төрсний гэрчилгээг гэрт нь бичиж гардуулах

Төрсний бүртгэлийг хөтлөхтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг угтаж аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасагт “Шинээр төрсөн хүүхдийг төрсний бүртгэлд бүртгүүлэх”-тэй холбоотой мэдээлэл, зөвлөмж өгөх зорилго бүхий самбарыг байршуулж 10, 11 дүгээр саруудад шинээр төрсөн хүүхдийн төрсний гэрчилгээг гэртээ хүргүүлэн авах үйлчилгээг үзүүлснээр **НИЙТ 15 хүүхдийн төрсний гэрчилгээг гэрт нь гардууллаа.**



8. Улсын бүртгэгчдэд Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын онлайн сургалт зохион байгуулах

Хэлтсийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/1123 албан тоотоор хүсэлт явуулсны үндсэн дээр УБЕГ-ын нэгдсэн архиваас Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагтай хамтран 2020 оны 10 дугаар сарын 4-ны өдөр сумдын улсын бүртгэгч нарт “Мэдээллийн сан ашиглан лавлагаа мэдээлэл гаргах, лавлагаа олгоход анхаарах асуудал” сэдвээр онолын болон практик сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж нийт 20 сумдын иргэний улсын бүртгэгч бүрэн хамрагдав.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжийн хүрээнд УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2020 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажилласан хэдийч 2020

онд дэлхий даяар үүсээд байгаа цар тахлын хөл хорио цээрийн дэглэмээс шалтгаалан 1-2 ажил үйлчилгээг бүрэн гүйцэт хэрэгжүүлж чадаагүй болно. 2021 онд дараах ажлуудад анхаарал хандуулахыг хүсч санал хүргүүлэв.

Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар

1.1. Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан, сул ажлын байр гарсан зэрэг тохиолдолд орны албан хаагчийг хугацаа алдахгүй томилдог байх;

1.2. Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай байгууллага хэвийн ажиллах үндсэн хөдөлгөгч хүч болох төсвийг 2022 оны төсвийн төслийг боловсруулахад сайтар анхаарч бусад хууль тогтоомжуудад байгууллага төсөвтөө тусган баталж хэрэгжүүлэхээр заасан зайлшгүй зардлуудыг тооцон батлуулах зохион байгуулалтын арга хэмжээ

2. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар

2.1. Улсын бүртгэгч нарыг туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд өргөн хамруулах;

2.2 УБЕГ-ын албан хаагчдын дунд онол, практик, эрдэм шинжилгээний хурал, эссэ бичих, илтгэх чадварын уралдааныг байнга зохион байгуулах;

2.3 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний онцлогоос шалтгаалан бусад төрийн захиргааны албан хаагчдаас илүү цагаар ажилладаг, ачаалалтай байдаг дүгнэлт хийн нийгмийн хамгаалал, тусламж, дэмжлэгийн асуудлыг тодорхой түвшинд шуурхай шийдвэрлэхэд шаардлагатай төсвийг төсөвлөж батлуулах

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг бий болгоход ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАНГ НЭГТГЭН БИЧСЭН:
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.МӨНХЖАРГАЛ